6.11	Европын Холбооны ERASMUS+ хөтөлбөрийн санхүүжилттэй URGENT төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийг хангаж ажиллах	ажилтан			
6.12	Ажилтнуудын гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх, боловсрол олгоход анхаарч байгууллагаас зохих дэмжлэг үзүүлэх	ажилтан			
6.13	Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт	ажилтан			
7.	Бусад	ажилтан	33		10,000.0
Нийт дүн					62,920.0

1.8 Эрдэм шинжилгээний зардал

Эрдэм шинжилгээ, судалгааны зардлын хувьд тус институт нь нийт 63.5 сая төгрөгийн зардлыг төсөвлөсөн.

2023 онд “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” Улсын их хурлаар батлагдах шатандаа явж байгаатай холбоотойгоор дараагийн шатны онд “Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-г хэрэгжүүлэхтэй холбоотой хийгдэх дотоод болон гадаадын мэргэжилтэн, зөвлөхүүдтэй хамтарч эрдэм шинжилгээний хурал, арга хэмжээг зохион байгуулан ажиллахаар тооцоолов. Мөн Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний 4 боть ном хэвлүүлэх зардалд 37.6 сая төгрөг төсөвлөсөн. Энэхүү ерөнхий төлөвлөгөө батлагдсанаар яам, Засгийн газрын бүх агентлагууд, харьяа байгууллагууд, нийслэлийн бүх нутгийн захиргааны байгууллагууд, дүүргүүдэд хэвлэмэл ботийг хүргүүлнэ.

Институтын үндсэн үйл ажиллагааны нэг болох суурь судалгаа хийх ажлын төсөв мөн багтсан болно. Нийт үйл ажиллагааны зардлын 2% нь эрдэм шинжилгээний зардал байна.

Хүснэгт 13.

Эрдэм шинжилгээ, судалгааны зардал /мянган төгрөг

№	Эрдэм шинжилгээний үйл ажиллагааны төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Зардал /мян төг/
1	Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний 4 боть ном	Ширхэг	150	251.0	37,650.0
2	Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тараах гарын авлага	Ширхэг	196	6.8	1,323.0
3	Бусад эрдэм шинжилгээний бүтээл, ном	Ширхэг	40	100.0	4,000.0
5	Норм, норматив бүрдүүлэлт	Ширхэг	300	27.0	8,100.0
6	Суурь судалгаа хийх төсөв		3	2,500.0	18,000.0
Нийт дүн					63,573.0

*Суурь судалгаа хийх төсөвд судалгааны чиглэлийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх стратеги зорилтын хүрээнд хийх судалгааны төсөв багтсан. Үүнд:

- Ерөнхий төлөвлөгөөний хариуцсан чиглэлийн хэрэгжилтийн судалгаа
- Нийслэл Улаанбаатар хотын түүх соёлын үл хөдлөх өв дурсгалуудын зэрэглэлийг шинэчлэн тогтоох судалгаа
- Улаанбаатар хот болон бүсийн хэмжээнд одоо байгаа шугам сүлжээний насжилт, чанар, хүчин чадал, хамрах хүрээг нарийвчлан тодорхойлох судалгаа
- Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрэм, хөгжлийн судалгаа, төлөвлөлтийн концепци боловсруулах
- Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний мониторинг хийх журтыг боловсруулж, НИТХ-аар батлуулах



- Ерөнхий төлөвлөгөөний мониторинг хийхэд шаардлагатай суурь судалгаануудыг хийх
- Хот төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах арга зүйн судалгаа, хот төлөвлөлт болон архитектурын төлөвлөлтийн төсөл боловсруулах / Судалгаа, төлөвлөлт, хэрэгжилт, мониторингийг хэрхэн хийх дүрэм, арга зүй/

1.9 Шуудан холбооны зардал

2023 онд шуудан холбооны зардалд 15.3 сая төгрөгийг өмнөх оны гүйцэтгэлээр дүйцүүлэн төсөвлөв. Нийт үйл ажиллагааны зардлын 0.5% нь шуудан холбооны зардал байна.

Хүснэгт 14. Шуудан холбооны зардал /мянган төгрөг/

№	Зардал	Нэгж үнэ	Давтамж	Нийт дүн	Тайлбар
1	Хэвлэл захиалга	120.0	20	2,400.0	Дотоод өдөр тутмын хэвлэл
2	Буухиа шуудан	3.5	22	77.0	Буухиа шуудан – 3500*24 удаа
3	Энгийн шуудан	2.5	90	225.0	Энгийн -2500*90 удаа
5	Утасны зардал	250.0	12	3,000.0	Суурин утас - 6ш * 3,600 /сард дунджаар 250.0/
6	Интернет	600.0	12	7,200.0	600000*12сар /хурд нэмсэн
7	Кабель	200.0	12	2,400.0	Univision – 200000*12сар
Нийт дүн				15,302.0	

1.10 Тээврийн зардал

2023 онд тээврийн зардалд 26.7 сая төгрөгийг Институтын ажлын онцлогтой холбоотойгоор яам, агентлаг, бусад албан газруудад очих шаардлагатай учир хотын захиргааны шинэ байраас хотын төв орох мөн шатахууны үнийн нэмэгдэл зэргийг тооцоолов. Нийт үйл ажиллагааны зардлын 1.3% нь шатахууны зардал байна.

Хүснэгт 15. Шатахууны зардал /мянган төгрөг/

№	Нэр	Дунджаар өдөрт явах	Шатахуун зарцуулалт	Үнэ /литр/	Авто машины тоо	Нийт ажлын өдөр	Нийт зардал	Тайлбар
1	Байгууллагын өдөр тутмын хэрэгцээнд	60	20	2.4	1	254	7,315.0	Албаны хэрэгцээнд өдөрт дунджаар 60 км явна гэж тооцоолсон
2	Дуудлагын машины үйлчилгээ						1,508.8	Автомашин үйлчилгээ
3	Ажилчдын хэрэгцээнд	35	20	2.8	2	254	9,956.8	нүүсэнтэй холбоотойгоор ажилчид хотын төв орох шаардлага үүснэ гэж тооцоолов
4	Бусад						7,817.2	
Нийт дүн							26,670.0	

1.11 Засвар, үйлчилгээний зардал

Засвар үйлчилгээний зардлын хувьд 2023 онд нийслэлийн төр, захиргааны байгууллагын А блокоос Б блок руу нүүж байгаа тул оффисын өрөө тасалгааны тохижилтын засвар, архивын нүүлгэлтийн зардлыг төсөвлөв. Нийт үйл ажиллагааны зардлын 1.5% нь засвар үйлчилгээний зардал байна.

Хүснэгт 16. Засварын зардал /мянган төгрөг/

№	Зардлын нэр	Бүгд өртөг	Тайлбар
1	Оффисын өрөө тасалгааг өөрчлөн зохион байгуулах /Ажлын төсөв, засварын зургийг гаргах/	22,000.0	Хэлтсүүдийн тухайн нөхцөл дэхь засвар



2	Тоног төхөөрөмжийн зардал	3,400.0	Компьютер, тоног төхөөрөмж болон принтерийн завсарууд
3	Нүүлгэлт	15,000.0	Үүнд архивын нүүлгэлт, ирэх жилд дахин шинэ байрлуу нүүх зардлыг төсөвлөв
4	Бусад	8,000.0	
Нийт дүн		48,400.0	

1.12 Үйл ажиллагааны бус зардал

Үйл ажиллагааны бус зардалд дараах 12 төрлийн үйл ажиллагаанд нийт 205.6 сая төгрөгийн зардлыг 2023 онд төлөвлөв. Нийт үйл ажиллагааны зардлын 6.4% нь засвар үйлчилгээний зардал байна.

Хүснэгт 17. Үйл ажиллагааны бус зардлын тооцоо /мянган төгрөг/

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж өртөг	Нийт зардал	Тайлбар
1	Эрүүл мэндийн үзлэг	Ажил тан	5	500.0	2,500.0	Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах Эрт илрүүлгээр үзүүлэх
2	Нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх	Ажил тан	2	25,000.0	50,000.0	Нэг удаагийн буцалтгүй тусламж, Орон сууцны дэмжлэг үзүүлэх
3	Хүүхдийн бэлэг	Удаа	95	25.0	4,750.0	Жилд 2 удаа /хүүхдийн баяр, шинэ жилээр хүүхдүүдэд бэлэг өгөх/
4	Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх	Ахмад	24	100.0	9,800.0	Ахмадын өдрөөр ахмад ажилтнууддаа хүндэтгэл үзүүлэх 23 ахмадад 2 удаа, бусад хүндэтгэл
5	Шинэ хүүхдийн мөнгө	Хүн	10	100.0	1,000.0	Байгууллагын ажилтнуудын шинэ төрсөн хүүхдэд нэг удаагийн буцалтгүй тусламж өгөх
6	Хүүхэд хамтдаа	Хүн	60	50.0	3,000.0	Гэр бүлийн өдөрлөг зохион байгуулах /гэр бүл-3/
7	Явган аялал	Хүн	81	20.0	1,620.0	Ажилчдын эрүүл мэнд, биеийн тамирын бэлтгэл болох үүднээс спортын тэмцээн /сагсан бөмбөг, гар бөмбөг, бусад/ зохион байгуулах
8	Нийслэлийн спорт арга хэмжээ	Хүн	40	11.0	440.0	Жил болгон зохион байгуулагддаг нийслэлийн харьяа байгууллагуудын спортын арга хэмжээ
9	Ар гэрийн гачигдал	Хүн	15	300.0	4,500.0	Ажилчдын ар гэрийн гачигдал гарах үеийн дэмжлэг
10	Соёл урлагын арга хэмжээ	Удаа	2	2,500.0	5,000.0	Байгууллагын урлагын арга хэмжээ
11	Шинэ гэр бүлд дэмжлэг үзүүлэх	Удаа	6	500.0	3,000.0	Шинээр гэр бүл болсон ажилчдад өгөх дэмжлэг
12	Нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх -1				120,000.0	Зуслангийн газар дээр төлөвлөлт хийх, ажилтнуудад олгох ажлыг зохион байгуулах, байр барихад нь байгууллагын зүгээс санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх
Нийт дүн					205,610.0	

ЗОРИЛТ ГУРАВ: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Байгууллагын зорилтын хүрээнд хүний нөөцийг сургах, хөгжүүлэх, хуваарилах, мэргэшсэн ажилтнуудыг сонгох, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах асуудлыг шийдвэрлэж, чадварлаг мэргэшсэн хүний нөөц бүхий байгууллага бий болгоход оршино.

Институтын үнэт зүйл нь мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн, чадварлаг, зарчимч боловсон хүчин тул 2023 онд ажилтан, албан хаагчдынхаа өмнө хүлээх хариуцлагаа нэмэгдүүлж ажлын байрыг хадгалж, тогтворжуулах үүднээс хүний нөөцийн



хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шаардлагатай сул орон тоог нөхөх замаар ажлын ачааллыг бууруулах, албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх, байгууллагын уур амьсгал, соёлыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөв.

1. Хүний нөөцийн хөгжил хөтөлбөр

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд институтын цаашид өсөн дэвших боломжтой, тогтвортой ажиллах албан хаагчидын нийгмийн баталгааг сайжруулах үүднээс нэг удаагийн буцалтгүй тусламж олгох, орон сууцанд хамрагдахад дэмжлэг үзүүлэх, ажилчдын өөрсдийн зуслангийн газартай, амины орон сууц барихад нь тусламж дэмжлэг үзүүлэх мөн мэргэшлийн зүгээс мэргэшүүлэх сургалтын төлбөрийг төлөх зэрэг олон арга хэмжээг төлөвлөв.

Хүснэгт 18. Хүний нөөцийн хөгжил хөтөлбөр

Хөтөлбөрийн үйл ажиллагааны ангилал	Хамрагдах хүний тоо	Тайлбар
Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох	2	Байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан, цаашид өсөн дэвших боломжтой, байгууллагын цаашдын хөгжилд мэдэгдэхүйц хувь нэмэр оруулах, тусламж зайлшгүй шаардлагатай байгаа
Орон сууцанд хамрагдахад дэмжлэг үзүүлэх	15	Байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан, цаашид өсөн дэвших боломжтой, гэр хороолол эсвэл түрээсийн сууцанд амьдардаг
Мэргэшүүлэх сургалтад хамрагдахад дэмжлэг үзүүлэх	9	Сургалтад хамрагдсан сэдвийн хүрээнд байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хувь нэмэр оруулах, сурч мэдсэн зүйлээ хамт ажиллагсадтайгаа хуваалцах

2. Албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх

Энэ дэд зорилтын хүрээнд мэргэшүүлэх сургалтад шаардлага хангасан мэргэжилтнүүдийг хамруулж мэргэшлийн зэрэг шинээр авах холбогдох мэргэжилтнүүдийг цахимаар болон танхимын сургалтад хамруулна. Сургалтуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 19. Мэргэшүүлэх сургалт

№	Сургалт	Мэргэжилтэн
1	Мэргэшсэн зэрэг авах /Шинээр/	М.Буянцэцэг
2		С.Үүрцайх
3		Б.Лхагвасүрэн
4		Н.Алтандөш
5	Мэргэшсэн зэрэг сунгах	М.Жавхлан
6		С.Вандандорж
7		Э.Уянга
8		Н.Мөнхзул
9	Зөвлөх зэрэг авах /Шинээр/	Н.Батмөнх
10		С.Ууганбаяр
11	А3 сертификат авах	
	Магистрд сурах	Э.Баярмагнай – Хот бүс нутаг төлөвлөлт

Хүснэгт 20. Мэргэжил дээшлүүлэх сургалт



Сургалтын нэр	Хамрагдах мэргэжилтнүүд	Зохион байгуулагдах хэлбэр	Хамрагдах хүний тоо
Мэргэжил дээшлүүлэх сургалт /Санхүү, маркетинг, менежментийн чиглэлээр/	Мэргэжилтнүүд	Танхим, цахим	5
Шинэ програмын сургалт /ИТА ажилтнуудад зураг төслийн програм/	Мэргэжилтнүүд	Танхим, цахим	25
Чанарын удирдлагын сургалт	Мэргэжилтнүүд	Танхим, цахим	81

3. Шаардлагатай ажлын байрны орон тоог нөхөх

2023 онд шинээр авах шаардлагатай орон тоонд хүний нөөцийг бүрдүүлэн ажиллана. Одоо байгаа орон тоогоор нэг мэргэжилтэнд ирэх ажлын ачаалал нэмэгдэж байгаагаас үүдэн ажилчид ажлаас гарч улмаар туслан гүйцэтгэгч авч ажиллуулах шаардлага үүсэж байна. Мөн шинэ захиргааны байрлуу нүүсэнтэй холбоотойгоор ажлаас гарах хүний тоо нэмэгдсэн. Дараах ажлын байранд шинээр ажилтан авна.

1. Дэд бүтцийн хэлтэс

- 1.1. Сэргээгдэх эрчим хүчний судалгаа, төлөвлөлтийн мэргэжилтэн
- 1.2. Тээвэр логистик, судалгааны мэргэжилтэн

2. Хот төлөвлөлтийн хэлтэс

- 2.1. Архитектор
- 2.2. Бүс нутаг төлөвлөгч
- 2.3. Хөдөлгөөний эрчмийн судалгааны мэргэжилтэн
- 2.4. Газар зохион байгуулагч
- 2.5. Ландшафтын архитектор
- 2.6. Геодези, өндөржилтийн инженер

3. Эдийн засаг, судалгааны хэлтэс

- 3.1. Хот төлөвлөгч, судлаач
- 3.2. Эдийн засгийн судалгаа, төлөвлөлтийн мэргэжилтэн
- 3.3. Газар зохион байгуулалтын судалгаа, төлөвлөлтийн мэргэжилтэн
- 3.4. Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн судалгааны мэргэжилтэн
- 3.5. Зам тээврийн судалгааны мэргэжилтэн
- 3.6. Соёл урлаг, Аялал жуулчлалын судалгаа, төлөвлөлтийн мэргэжилтэн
- 3.7. Авто замын судалгаа, төлөвлөлтийн мэргэжилтэн
- 3.8. Тээврийн инженерчлэл, нийтийн тээвэр, ухаалаг тээврийн судалгаа, төлөвлөлтийн мэргэжилтэн

4. Архитектур төлөвлөлтийн хэлтэс

- 4.1. Барилгын бүтээц, дэвшилтэт технологийн судлаач
- 4.2. Архитектор – 2

5. Хотын дизайны хэлтэс

- 5.1 График дизайнер
- 5.2 Архитектор

6. Хяналт, судалгаа мониторингийн хэлтэс

- 6.1 Судалгаа, үнэлгээний мэргэжилтэн - 3



2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Өөрийн хөрөнгийн санхүүжилтээр:

Ажлын байрны шаардлагатай орон тооны үзүүлэлт сайтай нийт 24 нэр төрлөөс 7 компьютер, 17 тоног төхөөрөмжийг 131,7 сая төгрөгөөр авахаар төсөвлөв. Институтын хэлтсүүд олон төрлийн өндөр хүчин чадалтай программ дээр ажилладаг учир хүчин чадал сайтай компьютер хэрэгтэй.

Мөн их хэмжээний судалгааны ажил, даалгаварт, төлөвлөгөөт, тендер сонгон шалгаруулалтаар шалгарсан гэрээт ажлуудын тендерийн материал бэлтгэх, өдөр тутмын эрх зүйн баримт бичгүүдийг боловсруулах, гэрээ байгуулах, шат шатны тайлангийн танилцуулга материал бэлтгэх, захиалагч байгууллагад 3-аас 5 хувь А4, А3, А0, А1 форматаар хэвлэн хүргэх, тухай бүр засвар тодруулгыг гүйцэтгэх, хийж гүйцэтгэсэн зураг төслийн ажлуудыг архивлах зэрэг Институтын зураг төслийн үйлдвэрлэлд зарцуулагдах бүх төрлийн принтерийн ашиглалтын хугацаа хурдан дуусаж эвдэрч гэмтдэг.

Хүснэгт 21. 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө/ мянган төгрөг

№	Хэлтсийн компьютер тоног төхөөрөмжийн захиалга	Нэгжийн үнэ*	Тоо ширхэг	Нийт дүн
1	1. Дэд бүтцийн хэлтэс			
2	1.1. Өнгөт принтер /Konica Minolta bizhub A3 color laser multi suction printer/ - 1 KYOCERA, Laser Colour, HyPAS™ solution platform	13,000.0	1	13,000.0
3	1.2. Тог баригч – 2	1,300.0	2	2,600.0
4	1.3. Иж бүрэн компьютер – 1	17,500.0	1	17,500.0
5	2. Эдийн засаг, судалгааны хэлтэс			-
6	2.1. Микрофонтой чихэвч – 4	200.0	4	800.0
7	2.2. Дэлгэц / Dell, 27inch/ - 1	900.0	1	900.0
8	2.3. Кофе чанагч - 1	200.0	1	200.0
9	3. Архитектур төлөвлөлтийн хэлтэс			-
10	3.1. Дэлгэц	900.0	1	900.0
11	3.2. Иж бүрэн компьютер /үзүүлэлт- CPU – i9* 12900kf*3.2GHz	17,500.0	1	17,500.0
12	3.3. Спикер - 1	68.5	1	68.5
13	4. Захиргаа, менежментийн хэлтэс			-
14	4.1. Компьютер/I7	4,900.0	2	9,800.0
15	5. Хот төлөвлөлтийн хэлтэс			-
16	5.1. Дэлгэц - 1	900.0	1	900.0
17	5.2. Компьютер/I9 13900k, Graphic card 4080, Ram 64gb/ - 1	17,500.0	1	17,500.0
18	6. Хотын дизайны хэлтэс			-
19	6.1. Компьютер /i9 – 9900CPU, RAM 64gb/ RTX 3080 - 1	17,500.0	1	17,500.0
20	6.2. Дэлгэц /27inch 4K UHD 3840x2160 40-60Hz/ SRGB – 2	900.0	1	900.0
21	6.3. Дэлгэц /34inch, QHD 21x9, 3440x1440/ - 1	1,700.0	1	1,700.0
22	7. Хяналт, судалгаа мониторингийн хэлтэс			-
23	7.1. Компьютер / HDD хард дээрээ нэмж 1 terra болон 1TB SSD хард (Arcgis 10.8, Arcmap Envi64, Envi classic64, Terraset, PIX4D, Metashape зэрэг мэргэжлийн програмууд дээр сансрын зургийн боловсруулалт хийхэд шаардлагатай) /	17,000.0	1	17,000.0
24	7.2. Өнгөт принтер /Konica Minolta bizhub 300i/	13,000.0	1	13,000.0
НИЙТ ДҮН			22	131,768.5



СУДАЛГААНЫ АЖЛЫН ЖАГСААЛТ /Хэлтсүүдээс ирсэн санал/

1. Байнга хийх судалгаа

- Ерөнхий төлөвлөгөөний хариуцсан чиглэлийн хэрэгжилтийн судалгаа
- Тухайн салбарын одоогийн нөхцөл байдлын судалгаа
- Гадаад орны хот төлөвлөлтийн туршлагын судалгаа
- Ирээдүйн чиг хандлагын талаарх судалгаа

2. Тодорхой хугацаанд хийх судалгаа

- Хот байгуулалтын баримт бичгийн одоогийн байдал, хот төлөвлөлтийн суурь судалгаа
- Техник эдийн засгийн үндэслэл / шинээр хийгдэх ажлын хүрээнд /
- Нийслэлийн нийгэм, эдийн засгийн үндсэн чиглэлд туссан зураг төслийн ажлуудаас гэрээ байгуулан хийх үед хийгдэх судалгаанууд

Хүснэгт 22. 2023 оны судалгааны ажлын задаргаа

Д д	Судалгааны нэрс /нарийвчлах/	Тайлбар	Практик ач холбогдол /хүлээгдэж буй үр дүн/	Хариуцаг ч /хувиарл ах санал/
1	Монгол оронд тохиромжтой барилгын материалын судалгаа	Улаанбаатар хотын хэмжээнд ирээдүйд бий болох хэрэгцээ шаардлагыг үндэслэн шаардлагатай барилгын материалын тоо хэмжээ болон барилгын материалын орд газрын судалгааг хийх		ЭЗСХ, АТХ, ИДБ
2	Ерөнхий төлөвлөгөөний хяналт мониторинг			ХСМХ
3	Монгол орны хот байгуулалтын судалгаа	Монгол орны хот байгуулалтын түүхэн дэхь эртний хот, балгас болон уран барилга, байгууламж өнөө үеийн хот байгуулалтын хөгжил, төрх байдал, тулгамдаж буй асуудлууд, үүссэн нөхцөл байдал зэргийг судлах		
4	Улаанбаатар хотын үйлдвэрийн бүсийн судалгаа	Үйлдвэрийн бүсийн одоогийн үүссэн нөхцөл байдлыг тодорхойлж, дахин зохион байгуулалт хийх шаардлага, кластер хэлбэрээр хөгжүүлэх боломж эсвэл нүүлгэн шилжүүлэх шаардлагатай эсэхийг тодорхойлох		ХТХ
5	Хамбын овооны цэцэрлэгт хүрээлэнгийн төлөвлөлт	21 аймгийн хэв шинж, язгуур урлагийг сурталчлан таниулах, тэрбум мод төслийн хүрээнд гэр хорооллын бүсэд хотын чанартай цэцэрлэгт хүрээлэнг бий болгох		АТХ, ХДХ
6	HUB/зангилаа/ концепц	Архитектур, инженерийн мэргэжилтнүүдийг нэг дор нэгтгэн төрөлжүүлснээр ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, баялагийг бүтээх, эдийн засгийн эргэлтэнд оруулах зэрэг ач холбогдолтой бөгөөд тус салбарын онцлогийг гаргасан архитектур, инженерийн шийдэл бүхий шинэ технологи, ажлын байр, дэд бүтцийг багтаасан суурьшлын төлөвлөлт хийх	Төрөл Бүрдэл	АТХ, ХДХ
7	Оёдлын үйлдвэр HUB- /зангилаа/			ХТХ
8	Нийтийн эдэлбэрийн талбайд эрхлэх өдрийн худалдааны жишиг загвар	Нийслэлийн нутаг дэвсгэрт зөвшөөрөгдсөн байршилд стандартын дагуу зориулалтын барилга, байгууламжид болон ил задгай худалдаа, үйлчилгээ эрхлэх орчин нөхцөлөөр хангах, хотын өнгө үзэмжийг сайжруулах, менежментийг тодорхойлох		
9	Автобусны буудлын одоогийн байдал, концепц	Автобусны буудлуудын өнгө үзэмжийг сайжруулах, тохьжуулах мөн ТҮЦ-тэй уялдуулан иргэдийг өвлийн улиралд дулаан орчинд автобус хүлээх нөхцөлөөр хангах, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх		ЭЗСХ
10	Тэрбум модны концепц	Улаанбаатар хотын хэмжээнд ногоон бүсийн хэмжээг нэмэгдүүлэх, эдийн засгийн хөшүүргийг тогтоох, шинэлэг бүтээлч санаануудыг		ХТХ, ЭЗСХ



		дэвшүүлэх, хэрэгжүүлэх менежментийг тодорхойлох /Хөрс, агрогрупп/		
11	Хот төлөвлөлтийн салбар дахь шинэ технологиудын судалгаа	Гадаад улс оронд болж буй үзэсгэлэнд мэргэжилтнүүдээс сонгон явуулах		Бүх хэлтэс
12	Улаанбаатар хотын хэмжээнд ипотекийн зээл олгохгүй бүс, ажлын байрыг дэмжих бүсийг тогтоох үндэслэл, ач холбогдол			ЭЗСХ
13	Сэдэвчилсэн бичил судалгааны дүн шинжилгээнүүд	Шийдвэр гаргагчид болон нийгмийг мэргэжлийн мэдээллээр хангаж байх зорилгоор байгууллагын сайтад тогтмол хугацаанд нийтлэж байх		ЭЗСХ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, МЕНЕЖМЕНТИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Л.ЭРДЭНЭБАТ

БОЛОВСРУУЛСАН:

Х.ДОЛГОРСҮРЭН

Хот төлөвлөлт, судалгааны институтын
Удирдах зөвлөлийн 2024 оны
02 дугаар сарын 22 - ны өдрийн
хурлын 01. тоот тогтоолын хавсралт



ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ – 2023

Улаанбаатар хот
2024 он



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА.....	3
Ерөнхий танилцуулга	3
Бүтэц зохион байгуулалтын ерөнхий схем	4
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ.....	6
Эрхэм зорилго, чиг үүрэг, алсын хараа, үнэт зүйл, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл.....	6
ГУРАВДУГААР БҮЛЭГ: 2023 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ	9
ЗОРИЛТ ХОЁР: ЦЭВЭР АШГИЙН ТҮВШИНГ ӨМНӨХ ОНЫ ЗОРИЛТООС БУУРУУЛАХГҮЙ БАЙХ.....	11
1. Зардлын задаргаа	12
1.1 Борлуулсан бүтээгдэхүүний өртөг.....	13
1.2 Цалингийн зардал	13
1.3 Түрээс, ашиглалтын зардал	14
1.4 Албан томилолтын зардал	14
1.5 Элэгдлийн зардал	15
1.6 Түүхий эд, материалын зардал.....	15
1.7 Сургалт, зар сурталчилгааны зардал	16
1.8 Шуудан холбооны зардал.....	18
1.9 Тээврийн зардал	18
1.10 Засвар, үйлчилгээний зардал	19
1.11 Үйл ажиллагааны бус зардал.....	19
ЗОРИЛТ ГУРАВ: ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ	20
2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
2023 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	Error! Bookmark not defined.



ХҮСНЭГТИЙН ТАЙЛБАР

.....	4
Хүснэгт 1. Батлагдсан орон тоо	4
Хүснэгт 1. 2023 оны борлуулалтын орлогын төлөвлөгөө /сая төгрөг/	10
Хүснэгт 4. “Сэлбэ сэргэлт” төслийн гүйцэтгэгч баг	12
2023 онд төлөвлөсөн зардлын нэгдсэн хүснэгт /мянган төгрөг/	12
Хүснэгт 5. ББӨ /мянган төгрөг/	13
Хүснэгт 6. Түрээс, ашиглалтын зардал /мянган төгрөг/	14
Хүснэгт 8. Элэгдлийн зардал /төгрөг/	15
Хүснэгт 9. Түүхий эд, хангамжийн материалын зардал / мянган төгрөг/	15
Хүснэгт 10. Зар сурталчилгааны зардал / мянган төгрөг/	16
Хүснэгт 11. Сургалтын зардал / мянган төгрөг/	16
Хүснэгт 12. Эрдэм шинжилгээ, судалгааны зардал / мянган төгрөг/	17
Хүснэгт 13. Шуудан холбооны зардал / мянган төгрөг/	18
Хүснэгт 14. Шатахууны зардал / мянган төгрөг/	18
Хүснэгт 15. Завсарын зардал / мянган төгрөг/	19
Хүснэгт 16. Үйл ажиллагааны бүс зардлын тооцоо / мянган төгрөг/	19
Хүснэгт 20. 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл/ төгрөг	24



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ТАНИЛЦУУЛГА

Ерөнхий танилцуулга

Нийслэлийн Зураг төслийн хүрээлэн нь анх 1964 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн тогтоолоор “Барилга засвар, шугам сүлжээний зураг төсвийн групп” нэртэйгээр байгуулагдсан бөгөөд өнгөрсөн 55 жилийн хугацаанд нэршил нь 10 удаа өөрчлөгдөн хамгийн сүүлд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 116 дугаар тогтоолоор “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ болж өөрчлөгдөн дүрэм нь батлагдсан.

Байршил: Хан-Уул дүүрэг, 4 дүгээр хороо, Яармаг, Шинэ захиргааны байр, А блок, 4 дүгээр давхар

Удирдлага: Сугирдоржийн Очир-Эрдэнэ нь Нийслэлийн Засаг даргын 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн Б/53 дугаар захирамжаар Хот төлөвлөлт, судалгааны Институтын даргаар томилогдон 2023 оны 05 дугаар сарын 10 хүртэл ажилласан.

Раднаагийн Амартүвшин нь Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ний өдрийн Б/60 дугаар захирамжаар Хот төлөвлөлт, судалгааны Институтын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байна.

Бүтэц орон тоо: Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын А/808 тоот захирамжаар 8 хэлтэс, 81 хүртэл орон тоотогоор ажиллаж байгаад Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн А/312 тоот захирамжаар 8 хэлтэс, 81 хүртэл орон тоотой болж өөрчлөгдөн батлагдсан байна.

Цахим хаяг: info@upri.ub.gov.mn

Вэб хаяг: www.upri.ub.gov.mn


Тус институтын үйл ажиллагааг зохицуулагч хууль эрх зүйн үндсэн баримт бичиг нь

- Иргэний тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль,
- Хот байгуулалтын тухай хууль,
- Барилгын тухай хууль,
- Зохиогчдын эрх болон түүнийг хамгаалах эрхийн тухай хууль,
- Газрын тухай хууль,
- Авто замын тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Нийслэлийн Иргэдийн Хурлын тогтоол,
- Нийслэлийн Засаг даргын захирамж, үйл ажиллагааны хөтөлбөр байна.



Бүтэц зохион байгуулалтын ерөнхий схем

Зураг 1. Бүтцийн схем



Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн А/312 тоот захирамжаар 8 хэлтэс, 81 хүртэл орон тоотой болж өөрчлөгдсөн байна.

- ✓ Захиргаа, удирдлагын хэлтсийг нийт 12 орон тоотойгоор шинээр Захиргаа, менежментийн хэлтэс болгон өөрчилсөн;
- ✓ Дэд бүтэц төлөвлөлтийн хэлтсийг Дэд бүтцийн хэлтэс;
- ✓ Ерөнхий төлөвлөгөөний хяналт мониторингийн хэлтсийг Хяналт, судалгаа мониторингийн хэлтэс;
- ✓ Хот байгуулалт, нийгэм эдийн засгийн судалгааны хэлтсийг Эдийн засаг, судалгааны хэлтэс болгон нэршлийг өөрчилсэн байна.
- ✓ Шинээр 2023 онд Зам, тээвэр судалгаа төлөвлөлтийн хэлтсийг нийт 12 орон тоотойгоор байгуулсан байна.

Хүснэгт 1. Батлагдсан орон тоо

№	Албан тушаал		Батлагдсан орон тоо	НЗД-ын батлагдсан захирамж	
				А/07 тоот	Шинээр А/808 тоот
		Нэг. Удирдлага			
1	Дарга		1	4	3
2	Орлогч дарга		2		
3	Ерөнхий инженер		1		



		Хоёр. Захиргаа, удирдлага санхүүгийн хэлтэс				
4	Хэлтсийн дарга		1	10	14 Маркетинг, менежментийн хэлтэс бүтцийн өөрчлөлтөд орсон.	
5	Ахлах мэргэжилтэн		2			
6	Мэргэжилтэн		3			
7	Захиргааны мэргэжилтэн		4			
		Гурав. Маркетинг, менежментийн хэлтэс				
14	Хэлтсийн дарга		1	7		
15	Ахлах мэргэжилтэн		1			
16	Мэргэжилтэн		5			
		Дөрөв. Хот төлөвлөлтийн хэлтэс				
20	Хэлтсийн дарга		1	12	14	
21	Ахлах мэргэжилтэн		2			
22	Мэргэжилтэн		9			
		Тав. Архитектур, төлөвлөлтийн хэлтэс				
27	Хэлтсийн дарга		1	7	8	
28	Ахлах мэргэжилтэн		1			
29	Мэргэжилтэн		5			
		Зургаа. Дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэс				
32	Хэлтсийн дарга		1	8	9	
33	Ахлах мэргэжилтэн		1			
34	Мэргэжилтэн		6			
		Долоо. Ерөнхий төлөвлөгөөний хяналт мониторингийн хэлтэс				
40	Хэлтсийн дарга		1	5	8	
41	Ахлах мэргэжилтэн		1			
42	Мэргэжилтэн		3			
		Найм. Хот байгуулалт, нийгэм эдийн засгийн судалгааны хэлтэс				
43	Хэлтсийн дарга		1	20	18	
44	Ахлах мэргэжилтэн		3			
45	Мэргэжилтэн		16			
		Ес. Инженерийн дэд бүтцийн судалгааны хэлтэс				
46	Хэлтсийн дарга		1	10		
47	Ахлах мэргэжилтэн		2			
48	Мэргэжилтэн		7			
Хотын дизайны хэлтэс						
49	Хэлтсийн дарга				8	
50	Ахлах мэргэжилтэн					
51	Мэргэжилтэн					
НИЙТ			83	83	81	



ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ

Эрхэм зорилго, чиг үүрэг, алсын хараа, үнэт зүйл, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Алсын хараа: Эрдэм шинжилгээ, тооцоо судалгаанд тулгуурласан олон улсад өрсөлдөх чадвартай Хот төлөвлөлт, судалгааны институт болох

Эрхэм зорилго: Түүх, соёл иргэншлийн уламжлал, бүсчилсэн хөгжлийн бодлого, хүрээлэн буй орчныг хамгаалах шаардлагад нийцүүлэн нийслэлийн хүн амын эрүүл, аюулгүй амьдрах тааламжтай орон зайн орчныг бүрдүүлэхийн тулд хот төлөвлөлтийн суурь судалгаа хийх, бүс нутаг, хот, тосгоны хөгжлийн төлөвлөлтийн зураг, төсөл боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж Хотын удирдлага, хот байгуулалтын салбарын байгууллагууд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг олон улсын жишигт нийцсэн хот төлөвлөлтийн эрдэм, шинжилгээ, судалгааны ажил, зураг төслөөр хангахад оршино.

Чиг үүрэг: Эрхэм зорилгоо хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хот төлөвлөлтийн суурь судалгааг хийх, хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засгийн нийгмийн зорилтод тусгагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрийн зураг төсөл болон бусад ТЭЗҮ, төсөл хөтөлбөр боловсруулах зэрэг үйл ажиллагааг эрхэлнэ.

Үнэт зүйл: Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн, чадварлаг, зарчимч боловсон хүчин

Удирдлагын манлайлал: Байгууллагын хөгжлийн ирээдүйн хандлагыг тодорхойлогч, бусдыг үлгэрлэн дагуулж, урам зориг, итгэл үнэмшлийг бадраах, бататгах, бодит үр дүнд хүрэх чадварыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Чин сэтгэл: Асуудлыг бүтээлчээр илрүүлж, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, төгөлдөршүүлэхийн төлөө тууштай зүтгэл мэргэжлийн өндөр түвшин, оновчтой санал, санаачлагыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Үнэнч шударга байдал: Хууль тогтоомжийг дээдлэн эрхэлсэн ажилдаа үнэнч шударга, өөриймсөг ханддаг сэтгэл, зүтгэлийг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Хамт олны нэгдмэл шинж чанар: Хамт олон бие биеэ харилцан хүндэтгэх, дэмжин туслах, итгэл, найдварыг даах, нэгдсэн санал, санаачилага, хүчин чармайлтыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Үр нөлөөтэй хяналт: Дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн ажлын явц, гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг байнга үнэлж дүгнэж ажиллах чадварыг бид үнэт зүйлс гэж үзнэ.

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл: Нийслэл Улаанбаатар хотын нийгэм, эдийн засгийн хөгжилд хамаарах, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засгийн нийгмийн зорилтод тусгагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрийн зураг төсөл болон бусад ТЭЗҮ, төсөл хөтөлбөр боловсруулах

Үйл ажиллагааны чиглэл: Эрхэм зорилгоо хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг эрхэлнэ.

- ✓ Хот төлөвлөлтийн суурь судалгааг хийх
 - Газар нутаг, хүн амын,
 - Эдийн засаг, хөрөнгө оруулалтын судалгаа
 - Нийгэм, соёлын судалгаа
 - Зам тээвэр, инженерийн дэд бүтцийн судалгаа
 - Байгаль орчин, аюулгүй байдлын судалгаа
 - Газар ашиглалт, барилгажилтын судалгаа



- Шаардлагатай бусад судалгааг хийх
- ✓ Хот байгуулалтын баримт бичгийг боловсруулах
 - Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл,
 - Бүсийн хөгжлийн төсөл,
 - Чөлөөт бүс, аялал, жуулчлал, дэд бүтцийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөө
 - хот тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө
 - хот тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
 - шинэ хороолол, бичил хорооллын төлөвлөгөө
 - барилга байгууламжийн зураг төсөл
 - хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө
 - хот, суурин газрыг дахин хөгжүүлэх төсөл
- ✓ Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, ойрын болон тухайн жилийн эдийн засаг нийгмийн зорилтод тусгагдсан ерөнхий төлөвлөгөө, барилга, байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрийн зураг төсөл болон бусад ТЭЗҮ, төсөл хөтөлбөр боловсруулах
- ✓ Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага"-ын баримт бичгийн ерөнхий зохиогчийн хувьд тус ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж байгаа явцад мониторинг хийж, биелэлтийг хоёр жил тутам гаргаж, Улсын Их Хуралд танилцуулах ажлын хэсэгт оролцож ажиллах ба түүнийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх салбаруудын мастер төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэл, хот байгуулалтын төсөл, хөтөлбөр боловсруулах, ерөнхий болон ХЕТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэх
- ✓ Хот байгуулалт, төлөвлөлт, барилга байгууламжийн төрөл бүрийн асуудлуудыг шийдвэрлэх эрдэм шинжилгээний суурь болон дагалдах хавсралт судалгаа, шинжилгээний төслүүд, техник эдийн засгийн үндэслэл боловсруулсны үндсэн дээр хэтийн болон дунд хугацааны хөгжлийн менежментийн төлөвлөгөө, төсөл хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх
- ✓ Төрийн болон гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, хувь иргэний захиалгаар хот, тосгодын ерөнхий төлөвлөгөө, ХЕТ, барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн болон авто зам, гүүрийн зураг төсөл боловсруулах зэрэг зураг төслийн байгууллагын хийж гүйцэтгэдэг нийтлэг үйл ажиллагааг эрхлэх
- ✓ Дотоод, гадаадын хөрөнгө оруулалтаар боловсруулсан хот байгуулалтын төсөл, хөтөлбөр, улс хотын чанартай томоохон барилга, байгууламжийн зураг төсөлд ерөнхий төлөвлөгөөний хүрээнд санал дүгнэлт өгөх
- ✓ Хот байгуулалт, төлөвлөлттэй холбоотой дүрэм, журам, норм, стандарт шинээр боловсруулах болон өөрчлөлт, шинэчлэлт оруулах санал боловсруулах
- ✓ Нийслэлийн хөгжлийн хэтийн төлөв, бүс нутгийн онцлогт нийцсэн нутаг дэвсгэрийн өсөлтийн менежмент, тэнцвэртэй хөгжил ба улс, бүс доторх хамтын ажиллагаа болон улс хоорондын хамтын ажиллагааны стратегийн санал боловсруулах
- ✓ Дотоод, гадаадын болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг татах, сургалт, судалгаанд зориулж өөрсдийн гүйцэтгэсэн ажлаар бүх төрлийн сурталчилгаа явуулах, ном, товхимол хэвлэх, үзэсгэлэн гаргах, онол практикийн хурал, зөвлөгөөн хийх ажлыг зохион байгуулах

Бүтээгдэхүүн үйлчилгээ - Бүтээгдэхүүн үйлчилгээний жагсаалт:

- Хот, тосгоны ерөнхий болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө



- Эрдэм шинжилгээний ажил /Хот төлөвлөлт, сэргээгдэх эрчим хүч, бие даасан дулаан, цахилгааны эх үүсвэрүүд/
- Барилга байгууламж, инженерийн дэд бүтцийн зураг төсөл боловсруулах, /Үүнд: Иргэдэд зориулан төвийн халаалттай орон сууц болон амины орон сууцны зураг төсөл гэх мэт/
- Олон улсын байгууллага, гадаад орны засаг захиргаа, бизнесийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зураг төсөл, хот төлөвлөлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах



ГУРАВДУГААР БҮЛЭГ: 2023 ОНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилт нэг: Борлуулалтын орлогыг өмнөх оны зорилтоос бууруулахгүй байх

2023 онд Ковид 19 цар тахлын сүүлийн үе шатны нөлөөлөлийн улмаас эдийн засгийн хурд удааширч, аж ахуйн нэгж байгууллагуудын үйл ажиллагаа зогсонги байдалтай байгаа үед боломжит эх сурвалжаас борлуулалтын орлогыг бүрдүүлэн өмнөх оны гүйцэтгэлээс бууруулахгүй байх зорилт тавин ажиллана. Энэхүү зорилтын хүрээнд дараах үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэнэ.

Борлуулалтын орлогын хувьд НӨАТ-гүй үнийн дүн нийт 3.32 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 24 орчим хувийг 2022-2023 он дамжин санхүүжих зөвлөх үйлчилгээний ажлаас бүрдүүлэх, 17 орчим хувийг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх судалгааны хэлтсийн албан хаагчдын цалин, 8 орчим хувийг яамдууд, нийслэлийн худалдан авах ажиллагааны газар, хөдөө орон нутагт хийгдэхээр төлөвлөсөн хот төлөвлөлт, барилга байгууламжийн зураг төслийн ажлын тендерийн сонгон шалгаруулалтад оролцох замаар бүрдүүлэх, бусад орлогыг Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээнээс олох орлогоос бүрдүүлэхээр төлөвлөв.

Зорилт хоёр: Цэвэр ашгийн түвшинг өмнөх оны гүйцэтгэлд дүйцүүлэх

Ашгийн хувьд өмнөх оны гүйцэтгэлд дүйцүүлэх зорилтыг дэвшүүлэв. Учир нь 2023 онд зардлын хэмжээ нэмэгдэх таамаглал байна. Нийслэлийн захиргааны шинэ байр ашиглалтад орсноор засвар үйлчилгээ, нүүлгэлт, шатахуун, шуудан холбооны зардал, хүний нөөцийн нөхөн болон шинэ бүрдүүлэлттэй холбоотой цалин, НДШ-ийн зардал, хөрөнгө оруулалтын зардлууд ажилчдын нийгмийн хэрэгцээг хангах үүднээс байгууллагын зуслангийн газар дээр төлөвлөлт хийх, ажилтнуудад олгох ажлыг зохион байгуулах зэргээс хамаарч зардал өмнөх оны зорилтоос нэмэгдэнэ гэж таамагласан. Зардал нэмэгдэж буй учир борлуулалтын орлогыг нэмэгдүүлнэ.

Зорилт гурав: Хүний нөөцийн хөгжил хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Институтийн үнэт зүйл нь мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай, мэргэшсэн, чадварлаг, зарчимч боловсон хүчин тул 2022 онд ажилтан, албан хаагчдынхаа өмнө хүлээх хариуцлагаа нэмэгдүүлж ажлын байрыг хадгалж, тогтворжуулах үүднээс хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, орон байраар хангахад туслах, зуслангийн байртай болгох, шаардлагатай сул орон тоог нөхөх замаар ажлын ачааллыг бууруулах, албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх, цалингийн хэмжээг нэмэгдүүлэх, байгууллагын уур амьсгал, соёлыг дээшлүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр төлөвлөв.

Зорилт дөрөв: Чанарын менежментийн тогтолцооны ISO:9001 стандартыг хэрэгжүүлэн нутагшуулах, гэрчилгээ авах.

ISO 9001 стандарт хэрэгжүүлэх ажлын явцад энэхүү стандартыг байгууллагын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэх, сайжруулалтыг хангах зорилгоор дараах байдлаар мөрдөн ажиллаж байна.

– Богино хугацаанд шахуу ачаалалтай захиалга гүйцэтгэдэг ажлын онцлогийг харгалзан байгууллагын бүтээмжийг дээшлүүлэх, чадамжийг сайжруулахад анхаарч, MNS ISO 30401:2021 Мэдлэгийн менежментийн тогтолцоо. Шаардлага олон улсын стандартад нийцүүлэн байгууллагын чадамжийг үнэлэх “Чадамжийн үнэлгээний заавар” боловсруулж, удирдлагуудаас санал авч, эцэслэн гаргах;

- Байгууллагын ЧМТ-ны хүрээнд мөрдөх 34 дотоодын шинжтэй баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулж, код тэмдэглэгээ олгон, тогтолцооны хүрээн дахь нэгдсэн жагсаалтад хамруулах;



ЗОРИЛТ НЭГ: БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНЫ ЗОРИЛТООС БУУРУУЛАХГҮЙ БАЙХ

2022 онд борлуулалтын орлогыг 3.04 тэрбум байх зорилт тавьж ажилласан бол 2023 онд 3.49 тэрбум төгрөгийн /НӨАТ орсон/ орлого бүрдүүлэхээр төлөвлөлөө. Үүнд:(НӨАТ-гүй үнийн дүн 3.18 тэрбум төгрөг).

2023 оны борлуулалтын орлогын 48 хувийг Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан нийслэлийн төсвийн болон бусад эх үүсвэрийн санхүүжилт, тендерийн сонгон шалгаруулалтаар 1.6 тэрбум төгрөгийн, он дамжин хийгдэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний орлогоос нийт 26 хувь буюу 893.4 сая төгрөг, 17 хувь буюу 610.0 сая төгрөгийг судалгааны ажилчдын үйл ажиллагааны зардалд санхүүжих нийслэлийн төсвийн санхүүжилтээр, 9 хувь буюу 300 сая төгрөгийг бусад орлогоос нийт 3.4 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байснаас орлогын биелэлт 4 дахин их буюу 13 тэрбум 7 сая төгрөг төвлөрсөн байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхий Сайдын 2023 оны 04 дүгээр сарын 11-ны өдрийн 70 дугаар захирамж, Монгол Улсын Шадар Сайд бөгөөд Эдийн Засаг, Хөгжлийн сайдын А/23 дугаар тушаал, Нийслэлийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр НЗДТГ 2023-А/492 дугаартай захирамж, Барилга, Хот Байгуулалтын Сайд, Нийслэлийн Засаг Даргын хамтран баталсан 2023/09 дугаартай “Сэлбэ сэргэлт” төслийн далан, зам, гүүрийн тохижилтын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг байгууллагын үндсэн чиг үүргийн дагуу хийж гүйцэтгэсэнтэй холбоотой.

Хүснэгт 1. 2023 оны борлуулалтын орлогын төлөвлөгөө /сая төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээнээс олох орлого	1,539.6	12,349.08	95%
Он дамжин санхүүжүүлэх борлуулалтын орлого	812.2	97.694358	1%
Нийслэлийн төсвөөс санхүүжих орлого	554.5	554.6	4%
Дүрмийн 8.1.2. Зохиогчийн хяналтаас олох	272.7	6.16598	0%
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	3,179.1	13,007.54	100%

2023 оны борлуулалтын орлогыг санхүүжилтийн эх үүсвэрээр задлан харуулбал:

Хүснэгт 2. Санхүүжилтийн эх үүсвэр/ сая төгрөг

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Санхүүжсэн дүн	Эзлэх хувь
1	Борлуулалтын орлого - ААН	12,349.1	95%
2	Борлуулалтын орлого - Төсөв	554.6	4%
3	Борлуулалтын орлого - БХБЯ	39.7	0%
4	Борлуулалтын орлого - НХОГ	58.0	0%
5	Бусад орлого - Улсын төсөв, бусад	6.2	190%
	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	13,007.54	100%



ЗОРИЛТ ХОЁР: ЦЭВЭР АШГИЙН ТҮВШИНГ ӨМНӨХ ОНЫ ЗОРИЛТООС БУУРУУЛАХГҮЙ БАЙХ

Нийслэлийн Засаг Даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн “Эдийн засаг, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх зорилтот түвшин батлах тухай” А/688 дугаар захирамж, Өмчийн харилцааны газрын 2/464 тоот Зорилт хүргүүлэх тухай албан бичгээр манай байгууллагын 2023 оны нийт орлогыг 3,179,153.5 мянган төгрөг, зардлыг 3,029,558.2 мянган төгрөг, цэвэр ашгийг 149,595.3 мянган төгрөг, борлуулалтын орлогын нэг төгрөгт ногдох зардлыг 0,95 төгрөг, тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 131,768.5 мянган төгрөг байхаар баталсан.

Хүснэгт 3. 2023 оны бизнесийн төлөвлөгөөний гүйцэтгэл /мянган төгрөгөөр/

д/д	Үзүүлэлт	2022 он		2023 он		Хэтрэлт/хэмнэлт	
		Зорилт	Гүйцэтгэл	Хянасан	Гүйцэтгэл	Хэтрэлт/ хэмнэлт	Хувь
1.1	Борлуулалтын орлого	2,482,902.3	2,149,089.0	2,624,581.7	12,452,939.1	9,828,357.4	474%
1.2	Нийслэлийн төсвөөс	559,327.3	559,334.4	554,571.8	554,571.1	-	100%
1	Нийт орлогын дүн	3,042,229.6	2,708,423.4	3,179,153.5	13,007,510.1	9,828,356.6	409%
2.1	ББӨ	327,952.3	752,319.3	419,933.1	9,876,145.6	9,456,212.5	2352%
2.2	Цалин, нэмэгдэл	1,395,499.1	987,236.9	1,504,194.9	1,629,683.6	125,488.6	108%
2.3	Хоол,унаа	204,820.0	111,260.0	174,510.0	149,330.0	- 25,180.0	86%
2.4	НДШ	216,043.1	148,395.6	209,838.1	227,819.7	17,981.5	109%
2.5	Түрээс, ашиглалт	76,200.0	47,059.0	50,000.0	47,604.4	- 2,395.6	95%
2.6	Албан томилолтын зардал	49,868.0	40,997.5	60,500.0	59,073.2	- 1,426.8	98%
2.7	Элэгдлийн зардал	101,891.7	91,281.8	91,082.2	97,516.6	6,434.4	107%
2.8	Түүхий эд материалын зардал	80,314.9	75,575.4	71,598.6	107,773.9	36,175.3	151%
2.9	Зар сурталчилгааны зардал	4,625.0	1,340.9	23,099.6	5,034.1	- 18,065.5	22%
2.10.	Сургалтын зардал	86,360.0	16,945.1	62,020.0	21,149.3	- 40,870.7	34%
2.11	Эрдэм шинжилгээ	75,573.0	66,360.9	63,573.0	59,123.7	- 4,449.3	93%
2.12	Шуудан холбооны зардал	17,802.0	8,879.9	15,302.0	10,103.2	- 5,198.8	66%
2.13	Шатахууны зардал	35,560.0	24,009.1	26,670.0	24,474.8	- 2,195.2	92%
2.14	Засварын зардал	51,000.0	45,811.1	48,400.0	58,224.0	9,824.0	120%
2.15	УЗ-н зардал	29,602.0	28,299.6	37,125.0	37,125.0	-	100%
2	Үйл ажиллагааны зардал	2,753,111.1	2,445,772.1	2,857,846.5	12,410,180.9	9,552,334.4	434%
3	Үйл ажиллагааны бус зардал	132,090.0	111,237.9	155,090.0	82,549.0	- 72,541.0	53%
4	Нийт зардал	2,885,201.1	2,557,010.0	3,012,936.5	12,492,729.9	9,479,793.4	415%
5	Татвар төлөхийн өмнөх ашиг	157,028.4	151,413.5	166,217.0	514,780.2	348,563.2	310%
6	Татварын зардал	15,702.8	21,981.0	16,621.7	51,844.2	35,222.5	312%
7	Цэвэр ашиг	141,325.6	129,432.5	149,595.3	462,936.0	313,340.7	309%
8	БОНТНЗ	0.95	0.95	0.95	0.96	0.0	101%
9	Авлага	619,655.4	643,859.7	619,655.4	790,298.8	170,643.4	128%
